



ХЭНГИЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ

2022 оны 04 сарын 06 өдөр

Дугаар 1/16

Хэрлэн сум

Урьдчилан сэргийлэх үзлэгт
хөрөнгө зарцуулах тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5, Төрийн албаны тухай хуулийн 55 дугаар зүйлийн 55.3, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5, 16.5.5 дахь заалт, аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын 2021 оны А/19 дүгээр тушаалын “Албан хаагчдын ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр”-ийн 5 дугаар зүйлийн 5.2.2, Засаг даргын Тамгын газрын дотоод журмын 8.7-д заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Аймгийн Засаг даргын Тамгын газрын ажил үүргээ гүйцэтгэж буй албан хаагчдыг урьдчилан сэргийлэх үзлэгт, шинжилгээнд хамруулахад 9,324,080 (есөн сая гурван зуун хорин дөрвөн мянга наян) төгрөгийг зарцуулсугай.

2. Зардлын задаргааг нэгдүгээр хавсралтаар, албан хаагчдын нэрсийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Дээрх зардалд зарцуулах хөрөнгийг аймгийн Засаг даргын Тамгын газрын нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшууллын зардлаас гаргахыг нягтлан бодогч (Э.Ариунтунгалаг)-д зөвшөөрсүгэй.

ДАРГА



Ж.ГАНБААТАР

231030170